



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/54/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас:260512 Цахим хаяг:natsagdorjs@audit.gov.mn Аудитор: Э.Булганчимэг Утас:260512 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал:Н.Цэрэнханд Утас: 99901517 Цахим хаяг:tsegtstuvbogd@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХДТ	Хүүхэд хөгжлийн дэмжих танхим



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/396
танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,825,730.4 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тогтоосон дээд хязгаараас хэтрүүлэн 8,194.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн;
- Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,817,535.9 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10.1, 40.2.1, 44.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Австралийн “Хүүхдийг Ивээх сан”-аас 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдөр төслийн хэрэгжих хугацааг сунгах хүсэлтийг “Боловсролын дэлхийн түншлэл” олон улсын байгууллагад хүргүүлснээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төсөл нь тайлант онд 188,285.9 мянган төгрөгөөр зорилтот сургуулийн хүүхэд хөгжлийг дэмжих танхимыг тохижуулж, 5,411,133.6 мянган төгрөгийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмж, 1,251,491.7 мянган төгрөгийн сургуулийн дижитал тоног төхөөрөмж, нийт 6,850,911.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.А.Ц.* Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,206,345,082.86	122,578,171.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,206,303,082.86	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөгөөр/	5,206,303,082.86	-
31211	Төрийн сангийн харилцах	863,391,633.18	
31220	Гадаад валют	4,342,911,449.68	
31221	Төрийн сангийн харилцах	4,342,911,449.68	
33	АВЛАГА	42,000.00	42,000.00
33402	Бусад авлага	42,000.00	42,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	122,536,171.08
34600	Урьдчилж гарсан зардал		122,536,171.08
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,837,087.43	17,706,422.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,837,087.43	17,706,422.46
39200	Биет хөрөнгө	23,837,087.43	17,706,422.46
39205	Машин, тоног төхөөрөмж	24,192,372.00	25,242,372.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,817,914.17)	(15,816,563.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,829,900.00	11,829,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,367,270.40)	(3,549,286.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,230,182,170.29	140,284,593.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	138,008,558.00	
41	Богино хугацаат өр, төлбөр	138,008,558.00	-
41300	Өглөг	138,008,558.00	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	42,000.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	137,966,558.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,092,173,612.29	140,284,593.54
51200	Хуримтлагдсан үр дүн	5,092,173,612.29	140,284,593.54
51210	Өмнөх үеийн үд дүн	41,112,233.45	5,092,173,612.29
51220	Тайлант үеийн үр дүн	5,051,061,378.84	(4,951,889,018.75)
6	ӨР, ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,230,182,170.29	140,284,593.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,002,003,974.08	4,147,340,809.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,002,003,974.08	4,147,340,809.35
120	Нийтлэг татварын бус орлого	217,103,888.96	630,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого	216,298,888.96	-
120009	Бусад орлого	805,000.00	630,000.00
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	10,784,900,085.12	4,146,710,809.35
122002	Хандив тусламж/гадаад/	10,784,900,085.12	4,146,710,809.35
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,184,183,508.34	1,951,912,247.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,184,183,508.34	1,951,912,247.05
210	БАРАА,АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,184,183,508.34	1,951,912,247.05
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	194,527,731.01	218,533,414.59
210101	Үндсэн цалин	194,527,731.01	218,533,414.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,315,966.00	27,316,677.33
210201	Тэтгэврийн даатгалын зардал		17,876,677.33
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		2,360,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		1,180,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		1,180,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		4,720,000.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	48,077,925.15	48,968,499.15
210301	Гэрэл цахилгаан	3,677,925.15	
210304	Байрны түрээс	44,400,000.00	48,968,499.15
2104	Хангамж бараа материалын зардал	6,128,240.90	4,741,749.28
210401	Бичиг хэргийн материал	3,462,240.90	2,212,637.28
210403	Шуудан холбооны зардал	2,400,000.00	2,400,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	266,000.00	129,112.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	570,013.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	570,013.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	24,737,390.00	7,017,856.00
210702	Дотоод томилолтын зардал	24,367,100.00	7,017,856.00
210703	Гадаад зочны зардал	370,290.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,878,579,892.46	1,637,853,385.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,878,579,892.46	1,637,853,385.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,246,349.82	7,180,664.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,246,349.82	7,180,664.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,817,820,465.74	2,195,428,562.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	27,623,992.54	148,805,098.91
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /бодит/	27,623,992.54	148,805,098.91
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,794,383,079.44	7,296,122,679.96
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	2,794,383,079.44	7,296,122,679.96
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	5,051,061,378.84	(4,951,889,018.75)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,785,705,085.12	2,955,503,877.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,785,705,085.12	2,955,503,877.12
120	Нийтлэг татварын бус орлого	805,000.00	630,000.00
120009	Бусад орлого	805,000.00	630,000.00
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	10,784,900,085.12	2,954,873,877.12
122002	Хандив тусламж /гадаад/	10,784,900,085.12	2,954,873,877.12
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,657,270,209.19	1,459,700,808.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,657,270,209.19	1,459,700,808.43
210	БАРАА,АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,657,270,209.19	1,459,700,808.43
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	194,499,731.20	218,575,414.59
210101	Үндсэн цалин	194,499,731.20	218,575,414.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,315,966.00	27,316,677.33
210201	Тэтгэврийн даатгалын зардал	15,354,841.00	17,876,677.23
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	2,038,000.00	2,360,000
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,828,125.00	1,180,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,828,125.00	1,180,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	4,076,000.00	4,720,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,777,925.15	57,936,999.15
210301	Гэрэл цахилгааны зардал	3,677,925.15	4,899,999.15
210304	Байрны түрээсийн зардал	41,100,000.00	53,037,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,128,240.90	5,341,749.28
210401	Бичиг хэргийн материал	3,462,240.90	2,212,637.28
210403	Шуудан холбооны зардал	2,400,000.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	266,000.00	129,112.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	570,013.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	570,013.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	24,737,390.00	54,012,000.00
210702	Дотоод томилолтын зардал	24,367,100.00	54,012,000.00
210703	Гадаад зочны зардал	370,290.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,655,171,717.50	1,096,217,968.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,655,171,717.50	1,096,217,968.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,707,069,225.44	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,707,069,225.44	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5128,434,875.93	1,495,803,068.69
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	6,850,911,250.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,850,911,250.46
222001	Тоног төхөөрөмж	-	6,850,911,250.46
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ	-	(6,850,911,250.46)
131	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ДҮН	27,623,992.54	148,805,098.91
145001	Валютын ханшийн зөрүү	27,623,992.54	148,805,098.91
8	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	27,623,992.54	148,805,098.91
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,156,058,868.47	(5,206,303,082.86)
101	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	50,244,214.39	5,206,303,082.86
20	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,206,303,082.86	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		41,112,233.45	41,112,233.45
2	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт		-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		41,112,233.45	41,112,233.45
9	Тайлант үеийн үр дүн		5,051,061,378.84	5,051,061,378.84
10	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		5,092,173,612.29	5,092,173,612.29
12	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт		-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		5,092,173,612.29	5,092,173,612.29
19	Тайлант үеийн үр дүн		(4,951,889,018.75)	(4,951,889,018.75)
20	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		140,284,593.54	140,284,593.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,738,136,000.00	3,104,308,976.03	5,633,827,023.97	35.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,738,136,000.00	2,955,503,877.12	5,782,632,122.88	33.8
120	Нийтлэг татварын бус орлого		630,000.00	(630,000.00)	
120009	Бусад орлого		630,000.00	(630,000.00)	-
122	Тусламжийн орлого	8,738,136,000.00	2,954,873,877.12	5,783,262,122.88	33.8
122002	Хандив тусламж/гадаад/	8,738,136,000.00	2,954,873,877.12	5,783,262,122.88	33.8
14	Бусад олз		148,805,098.91	(148,805,098.91)	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз		148,805,098.91	(148,805,098.91)	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,738,136,000.00	8,310,612,058.89	427,523,941.11	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,578,136,000.00	1,459,700,808.43	118,435,191.57	92.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,578,136,000.00	1,459,700,808.43	118,435,191.57	92.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,000,000.00	218,575,414.59	17,424,585.41	92.6
210101	Үндсэн цалин	236,000,000.00	218,575,414.59	17,424,585.41	92.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,500,000.00	27,316,677.33	2,183,322.67	92.6
210201	Тэтгэврийн даатгал	20,060,000.00	17,876,677.33	2,183,322.67	89.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,360,000.00	2,360,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,180,000.00	1,180,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,180,000.00	1,180,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,720,000.00	4,720,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,800,000.00	57,936,999.15	5,863,000.85	
210301	Гэрэл, цахилгаан	4,900,000.00	4,899,999.15	0.85	100.0
210304	Байрны түрээс	58,900,000.00	53,037,000.00	5,863,000.00	90.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,336,000.00	5,341,749.28	1,994,250.72	72.8
210401	Бичиг хэрэг	3,706,000.00	2,212,637.28	1,493,362.72	59.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	630,000.00	129,112.00	500,888.00	20.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,000.00	300,000.00	600,000.00	33.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	900,000.00	300,000.00	600,000.00	33.3
2107	Томилолт, зочны зардал	62,000,000.00	54,012,000.00	7,988,000.00	87.1
210702	Дотоод албан томилолт	60,000,000.00	54,012,000.00	5,988,000.00	90.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	-	2,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,178,600,000.00	1,096,217,968.08	82,382,031.92	93.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,178,600,000.00	1,096,217,968.08	82,382,031.92	93.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,160,000,000.00	6,850,911,250.46	309,088,749.54	95.7
222001	Тоног төхөөрөмж	7,160,000,000.00	6,850,911,250.46	309,088,749.54	95.7
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		(5,206,303,082.86)		

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	5,206,303,082.86		
7	Харилцах ба хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	5,206,303,082.86		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,206,303,082.86		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4.00	4.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл нь зорилгоо “Монгол улсын боловсролын салбарт тэгш хамруулах замаар боловсролын хүртээмж, чанарыг сайжруулна” гэж тодорхойлсон байна.

Тус төсөл нь 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Австралийн “Хүүхдийг ивээх сан”-гийн санхүүжилтээр 5,000.0 мянган ам.долларын буцалтгүй тусламжаар боловсролын салбарт тэгш хамруулах замаар боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах зорилтын хүрээнд хоол тэжээлийн тэнцвэртэй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан сургуулийн үдийн хоол үйлдвэрлэх аюулгүй орчныг бүрдүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн хангалттай үйлчилгээ авч чадахгүй байгаа тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хооллолтын нөхцөл байдлыг сайжруулах, ерөнхий боловсролын зорилтот сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх, тэднийг суралцахад нь дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, хосолсон сургалтыг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын тогтолцоог сайжруулах, нөхцөл байдалд тохирсон хосолсон сургалтын загварыг бий болгож, зорилтот сургуулиудад туршихад дэмжлэг үзүүлэх юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна.

Төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын хууль;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Төслийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч болох Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 2025 оны санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаагаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,089,897.6 мянган төгрөгөөр буюу 97.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,206,303.1	-	(5,206,303.1)
Авлага	42.0	42.0	-
Урьдчилж гарсан зардал	-	122,536.2	122,536.2
Үндсэн хөрөнгө	23,837.1	17,706.4	(6,130.7)
Нийт хөрөнгө	5,230,182.2	140,284.6	(5,089,897.6)
Өр төлбөр	138,008.6	-	(138,008.6)
Засгийн газрын хувь оролцоо/эздийн өмч/	5,092,173.6	140,284.6	(4,951,889.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,230,182.2	140,284.6	(5,089,897.6)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,206,303.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өмнөх оны болон нэмэлтээр тоног төхөөрөмж худалдан авч зорилтот бүлгийн сургуулиудад өгч, гэрээтэй ажил, үйлчилгээний гэрээг дүгнэн үлдэгдэл санхүүжилтийг олгосонтой холбоотой байна;

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 122,536.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төслийн эцсийн тайланг гаргах хугацааг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасантай холбоотой цалин, байрны түрээс, интернэтийн төлбөрийг урьдчилж шилжүүлсэн байна;

Тайлант онд үндсэн хөрөнгийн цэвэр дүн худалдаж авсан 1,050.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 7,180.7 мянган төгрөгийн байгуулсан элэгдлийн дүнгээр буурсан үзүүлэлттэй байна.

Өр төлбөрийн данс өмнөх оны худалдаж авсан тоног төхөөрөмжийн баталгаат хугацааны барьцаа 138,008.6 мянган төгрөгийг буцаан олгож, үлдэгдэлгүй байна;

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,951,889.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны сөрөг үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн тайлант оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 8,738,136.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр Австралийн Хүүхдийг ивээх сангийн буцалтгүй тусламжаар 2,954,873.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, тендерийн материал борлуулсны орлого 630.0 мянган төгрөг бүрдүүлж, гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит олз 148,805.1 мянган төгрөг, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 5,206,303.1 мянган төгрөг, нийт 8,310,612.1 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 8,310,612.1 мянган төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	70207-Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр	8,738,136.0	8,310,612.1	427,523.9	95.1
2	80105-Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил	8,738,136.0	8,310,612.1	427,523.9	95.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант хугацаанд төслийн бүрэлдэхүүн I - тэгш хамран сургалт боловсролын хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсад буддын дацан, хийдэд шавилан суралцаж буй монгол хүүхдүүдийн сурах эрхийн нөхцөл байдлыг судлах, үнэлгээ хийх, боловсролын үйлчилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 3 хүний бүрэлдэхүүнтэй томилолтоор явсан ба 34,841.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус томилолтын үр дүнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсад буддын дацан, хийдэд шавилан суралцаж буй 433 хүүхдийг бүртгэн ерөнхий боловсролын үйлчилгээ авах, цахим сургалтын хөтөлбөрийг эхлүүлэхийг дэмжиж, сургалтын хөтөлбөрт хамрагдах удирдамжийг танилцуулан лам хүүхдүүдэд и-мэйл хаягуудыг нээж, хийдийн удирдлага болон холбоодтой уялдуулан хэрэгжүүлснээр боловсролд тэгш хамрагдах боломжийг хангасан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох, хоол тэжээлийн тусгай хэрэгцээт суралцагчдын хооллолтын байдлыг үнэлэх аргачлалыг танилцуулах, үдийн хоолны чанар хүртээмжид эцэг, эх асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн 36 “хоол зүйч”-ийг хөрвүүлэх

сургалтаар бэлтгэх, ерөнхий боловсролын сургуулийн тогооч нарыг чадавхжуулах зэрэг сургалтад 342,962.1 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Буцалтгүй тусламжийн гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 4,611.3 мянган доллар буюу 16,009,608.9 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, зарцуулсан ба Японы Хүүхдийг ивээх сангаас 1,351,457.0 мянган төгрөг, Австралийн Хүүхдийг ивээх сангаас 466,309.6 мянган төгрөгийг төслийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн хэрэгжилтэд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ, үнэлгээ хийх эцсийн судалгааны ажлын судалгаа, зөвлөх үйлчилгээг “Эс Ай Си Эй” ХХК хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү дүн шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр төсөл хэрэгжсэн 3 бүрэлдэхүүний хүрээнд тэгш хамран сургах боловсрол бүрэлдэхүүний үнэлгээ 99.2 хувь, үдийн хоол бүрэлдэхүүний үнэлгээ 95.0 хувь, хосолсон сургалт бүрэлдэхүүний үнэлгээ 97.5 хувь, төслийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 97.2 хувьтай гэж үнэлжээ.

Төсөл хэрэгжсэн 3 бүрэлдэхүүний үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

Бүрэлдэхүүн I Тэгш хамран сургах боловсрол- 2 дүүрэг, 4 аймгийн ерөнхий боловсролын 18 сургуульд ХХДТ-ыг шинээр байгуулж, нийт 4,761 багшийг чадавхжуулах сургалтад хамруулан, багш нарын хамтын ажиллагааг дэмжих 6 сүлжээ байгуулсан. Түүнчлэн ХХДТ-уудыг туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж, улмаар эдгээр танхимаар өдөр бүр 446 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тогтмол үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Мөн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 413 эцэг эх, асран хамгаалагчийг төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх чиглэлээр сургалтад хамруулжээ.

Төслийн 1-р бүрэлдэхүүний зорилтот сургууль байрладаг Хан-Уул, Сүхбаатар дүүрэг болон Архангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймаг-ийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг 78-аар нэмэгдүүлэх зорилтыг давуулан биелүүлж, нийт 355 хүүхдээр нэмэгдүүлсэн байна.

Бүрэлдэхүүн II Сургуулийн үдийн хоол – Зорилтот бүрэлдэхүүний хүрээнд Улаанбаатар хот болон орон нутгийн ерөнхий боловсролын нийт 45 сургуулийн гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг нийлүүлж, иж бүрэн тохижуулсан байна.

Хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд ерөнхий боловсролын сургуульд ажиллах мэргэжлийн 36 хоол зүйчийг хөрвүүлэх сургалтаар бэлтгэн, зорилтот сургуулиудад ажиллуулах боломжийг бүрдүүлсэн байна. Мөн зорилтот сургуулиудын 60 тогоочийг “Хүүхдийн хоолны тогооч” сэдэвт танхим, дадлага хосолсон сургалтад хамруулж, хүүхдийн хоолыг хэрхэн бэлтгэх талаарх мэдлэг олгожээ.

Мөн төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа “Орон нутаг болон алслагдсан бүсийн дотуур байрны сурагчдад зориулсан хүүхэд төвтэй хоол тэжээл, эрүүл мэндийн хөтөлбөр” болон 1–5, 6–9, 10–12 дугаар ангийн сурагчдад зориулсан гарын авлагууд, “Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтод дэмжлэг үзүүлэх

аргачлал"-ыг боловсруулж, зорилтот сургуулиудад туршин хэрэгжүүлсэн нь салбарын бодлого, арга зүйг шинэ түвшинд хүргэсэн байна.

Ингэснээр төслийн 2-р бүрэлдэхүүний үндсэн зорилго болох нийт 48,000 хүүхдийг ажлын таван өдөр халуун хоолоор тогтмол үйлчлүүлэх зорилтын хүрээнд хоол тэжээлийн мэдлэг олгох болон хүүхдийн эрүүл мэнд, шим тэжээлийг дэмжих нэмэлт үйл ажиллагаануудыг хамруулан хүртэгчдийн тоо 60,209 сурагчид хүрсэн байна.

Бүрэлдэхүүн III Хосолсон сургалт – Төсөл нь сургалтын чанарыг дэмжих зорилгоор зорилтот 50 сургуульд “Цахим танхим” байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, сургалтын шинэ арга зүйг сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд нийт 1,320 багш, аймаг болон сургуулийн түвшний 389 удирдах ажилтан, 121 мэдээллийн технологийн ажилтан, мөн 4,622 эцэг эхчүүдийг хамруулсан сургалт зохион байгуулсан байна.

Төслийн хүрээнд олон улсын ISO/IEC 2382-36:2019 стандартыг Монгол Улсын нөхцөлд нутагшуулан “MNS ISO/IEC 2382-36:2025” болгон боловсруулж, Стандарт хэмжил зүйн газраар батлуулсан байна.

“Хосолсон сургалтын арга зүй” гарын авлага боловсруулан гаргасан нь сургалтын арга зүйн тогтвортой хэрэгжилтийг дэмжих хэрэгсэл болсон байна.

Төслийн хэрэгжилтийн хугацаанд нэмэлтээр хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа

Нэмэлтээр 1,783,752.1 мянган төгрөгийн дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжих үйлчилгээний олон улсын туршлага судлах сургалт, солилцооны үйл ажиллагааг зохион байгуулж, нийслэлийн 3 дүүрэг, орон нутгийн 15 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийт 38 багшийг хамруулсан;
- Боловсролын яам, харьяа байгууллагууд, сургуулийн багш нар зэрэг нийт 50 албан хаагчийг Монгол дохионы хэлний сургалтад хамруулсан;
- БНЭУ-д суралцаж буй 431 ламхай хүүхдийг газар дээр нь бүртгэх, боловсролын үйлчилгээний хамралтад тэгш хамруулах үйл ажиллагааг зохион байгуулсан;
- Ерөнхий боловсролын сургуулиудын гал тогооны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах хүрээнд 150 сургуулийг автомат аяга таваг угаагчаар нэмэлтээр хангасан;
- Хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний тохируулга хийх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн;
- Сургуулийн үдийн хоолны үйлчилгээг сайжруулах зорилгоор ерөнхий боловсролын 14 сургуульд гал тогооны тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг нэмэлтээр нийлүүлсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бараа нийлүүлэх 6, үйлчилгээний 2 ажил, нийт 4,677,910.2 мянган төгрөгөөр 8 худалдан авах

ажиллагааг төлөвлөж, тайлант хугацаанд 6,850,911.2 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,817,535.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Үүнд:

- Зорилтот бүлгийн гал тогооны тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг 1,574,408.5 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж, 930,678.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан;
- Өмнөх онд гал тогооны тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл худалдан авах тендерт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг тайлант онд байгуулан 1,343,636.4 мянган төгрөг олгосон;
- ТБӨНОХБАҮХА тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-т заасан нөхцөлөөр нэмэлт гэрээ байгуулан 543,220.8 мянган төгрөгийн худалдан авалт тус тус хийсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Японы хүүхдийг ивээх сангаас төслийн хэрэгжилт, шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ үнэлгээ хийх үйлчилгээнд 82,616.0 мянган төгрөг, хэл яриа сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний тохируулга хийх үйлчилгээний төлбөрт 125,000.0 мянган төгрөг, ЕБС-д дижитал тоног төхөөрөмж нийлүүлэхэд 138,070.0 мянган төгрөг нийт 345,686.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 188,285.9 мянган төгрөгөөр зорилтот сургуулийн хүүхэд хөгжлийг дэмжих танхимыг тохижуулж, 5,411,133.6 мянган төгрөгийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмж, 1,251,491.7 мянган төгрөгийн сургуулийн дижитал тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүний нийт 6,850,911.2 мянган төгрөгийн хөрөнгийн зардал гарсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус төслийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх, урьдчилж гарсан зардал данс, бараа материалын тайлан гаргах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Цэгцтөв богд аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Өлзий-Орших, туслах аудитор П.Пунцаг нар гүйцэтгэж, аудитын менежер Т.Энхцэцэг, захирал Н.Цэрэнханд нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Булганчимэг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 32 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал 5,978,566.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 59,785.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус төсөл нь шилэн дансны цахим хуудаст 139 мэдээлэл байршуулахаас 29 мэдээллийг хугацаа хоцроож, 3,403,577.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, цалин хөлс, түрээсийн гэрээ, худалдан авах ажиллагааны хувьд горим, сорил хэрэгжүүллээ.

Завсрын аудитаар 241,146.4 мянган төгрөгийн алдаа, 8,194.5 мянган төгрөгийн зөрчил илэрснийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулж, жилийн эцэст алдааг залруулж, хэрэгжээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,988,764.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн бөгөөд шийдвэрийн хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.

Хүснэгт 4: Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2,988,764.3	1	2,988,764.3	100.0
Нийт дүн	1	2,988,764.3	1	2,988,764.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гадаадын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хаалтын санхүүгийн тайланг бэлтгэх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөрөнгийг шилжүүлсэн эсэхэд горим, сорил гүйцэтгэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 124,919.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

- Төслийн ажилтнуудын урьдчилж гарсан цалингийн зардал 65,973.5 мянган төгрөг, томилолтын зардал 46,994.2 мянган төгрөг, байрны түрээсийн 8,968.5 мянган төгрөг, интернэтийн төлбөр 600.0 мянган төгрөгийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна;
- 2024 оны хүн амын орлогын албан татварын авлага 42.0 мянган төгрөгийг цалингийн зардлаар бүртгэж, авлагын дансыг бууруулсан;
- Бичиг хэргийн материал 2,341.7 мянган төгрөгийг бараа материалын тооцооны болон бараа материалын дансанд бүртгэлгүй, шууд зардалд бүртгэсэн зэрэг нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27, 29 дүгээр параграфт заасантай тус тус нийцэхгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 2,825,730.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 2,825,730.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 59,785.7 давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тогтоосон дээд хязгаараас хэтрүүлэн 8,194.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөр илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 139-р тогтоолын 1-д "Төрийн өмчит хуулийн этгээд(төсөвт байгууллага бол батлагдсан төсөвт багтаан) -ийн бусдаас түрээслэх 1м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000 (тавин мянга) төгрөгөөр тогтоосугай", 3.1 "Бусдаас байр талбай түрээслэх бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл авч байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

2. Тус төсөл нь 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,817,535.9 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10.1 "тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн", 40 дугаар зүйлийн 40.2.1 "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.3-т "Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж		
								Үүнээс						
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1.	Төслийн тайлагналын үйл ажиллагаа 2026 оны 03 сарын 31-н дуусвар болохтой холбоотой цалин, байрны түрээс, интернэтийн зардлыг тайлант оны зардлаар бүртгэсэн.	1	122,536.2			1	122,536.2	1	122,536.2			-	-	-
2.	Хувь хүний орлогын татварын авлага 42.0 мянган төгрөгийг цалингийн зардлаар тайлагнасан.	1	42.0			1	42.0	1	42.0			-	-	-
3	Бараа материалын зардлыг шууд зардалд бүртгэсэн	1	2,341.7			1	2,341.7	1	2,341.7			-	-	-
	Дүн	3	124,919.9			3	124,919.9	3	124,919.9					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
1	Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1м.кв талбайн	1	8,194.5			1	8,194.5			-				

	1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг зөрчиж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөлгүйгээр 59.79 м.кв-д талбайг түрээслэхэд 8,194.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөр илүү төлсөн байна												
2	Тус төсөл нь 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,817,535.9 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.	1	2,817,535.9			1	2,817,535.9						
	Дүн	2	2,825,730.4	-	-	2	2,825,730.4						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 139 мэдээллээс 3,403,577.7 мянган төгрөгийн 5 мэдээлэл шилэн дансанд байршуулаагүй байна.	1	3,403,577.7	1	3,403,577.7		
	Дүн	1	3,403,577.7	1	3,403,577.7		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 439/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/54/НА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 139 мэдээллээс 3,403,577,726.00 /гурван тэрбум дөрвөн зуун гурван сая таван зуун далан долоон мянга долоон зуун хорин зургаан/ төгрөгийн 5 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн зохицуулагч /Б.Цэрэнханд/, санхүүгийн ажилтан /А.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 438/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/54/НА -СТА -ТХЧ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,817,535,873.29 /хоёр тэрбум найман зуун арван долоон сая таван зуун гучин таван мянга найман зуун далан гурван/ төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10.1 "тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн", 40 дугаар зүйлийн 40.2.1 "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.3 "Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн зохицуулагч /Цэрэнханд/, санхүүгийн ажилтан /А.Ганцэцэг/, Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн /Х.Еркегул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тайруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlagai2026/0125 SAG-82.Docx

1526181002



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 437/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/54/НА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тогтоосон дээд хязгаараас хэтрүүлэн 8,194,500.00 /найман сая нэг зуун ерэн дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 139 дүгээр тогтоолын 1 "Төрийн өмчит хуулийн этгээд /төсөвт байгууллага бол батлагдсан төсөвт багтаан/-ийн бусдаас түрээслэх 1м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000 /тавин мянга/ төгрөгөөр тогтоосугай", 3.1 "Бусдаас байр талбай түрээслэх бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл авч байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг мөрдөж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн зохицуулагч /Б.Цэрэнханд/, санхүүгийн ажилтан /А.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
ATA16037
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0125_SAG-82.Docx

1526181000